



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/Факс: (976-51) 26-02-47, <http://www.mof.gov.mn>

2011-7-21 № 3-1/2999

танай _____-ны № _____-т

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА НАРТ

Монгол Улсын 2012-2014 оны төсвийн төлөвлөгөөг бэлтгэх тухай

Улсын Их Хурлын 2011 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар “2012 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай” хуулийг баталсантай холбогдуулан түүнд суурилсан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2012 оны төсвийн хязгаарын төслийг боловсруулан үүгээр хүргүүлж байна. Төсвийн хязгаар нь суурь түвшинд үндэслэсэн (өөрөөр хэлбэл бодлогын өөрчлөлтгүй) төсвийн хязгаар бөгөөд бодлогын нөөцийн хуваарилалтын асуудлыг 2012 оны төсвийн төслийг боловсруулах явцад шийдвэрлэх болно.

Мөн Засгийн газрын 2008 оны 256 дугаар тогтоолын дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нар 8 дугаар сарын 15-ны дотор төсвийн хязгаарт суурилсан дараа жилийн төсвийн төслөө боловсруулан Сангийн яаманд хүргүүлэх ёстой. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2012 оны төсвийн хязгаар Засгийн газраар батлагдаагүй боловч цаг хугацааны давчуу байдлаас шалтгаалан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2012-2014 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжийг үүгээр хүргүүлж байна (Төсвийн төсөл бэлтгэх холбогдох хавсралтуудыг www.mof.gov.mn болон <http://iltod.gov.mn> вэб хаягаар хандан электрон хэлбэрээр авч болно).

Төсвийн хязгаарын төсөлд суурилан төсвийн төсөл бэлтгэх удирдамжийн дагуу 2012 оны төсвийн төсөл, 2013-2014 оны төсвийн төсөөллийг боловсруулан 2011 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт №1. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2012 оны төсвийн хязгаарыг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга болон хавсралт

Хавсралт №2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2012-2014 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж, маягтууд болон орон нутгийн төсвийн төсөл хянах хуваарь

ДЭД САЙД



Ч.ГАНХУЯГ

08 3011